

## СУЛ ОРОН ТОО НӨХӨХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйл, “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 4.4, 7.1-т заасныг тус тус үндэслэн сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд мэдээлж байна. /энд дарж журамтай танилцана уу/

**Нэг. Журамд заасан тавигдах шаардлага, бүрдүүлэх материалыг бүрэн хангасан иргэн бүртгүүлнэ.**

- Монгол Улсын иргэн байх;
- Дээд боловсролтой байх;
- Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй;
- Сэтгэцийн өвчин, эмгэггүй;
- Хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн үүргээ биелүүлсэн байх /Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтад оролцох иргэдэд хамааралгүй./;
- Төрийн албаны тухай хуулийн 46.2.2, 46.2.3-т заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөөгүй байх;
- Төрийн албанд эргэж орох эрхгүйгээр хугацаа зааж халсан эсхүл албан тушаал эрхлэх эрх хязгаарласан шүүхийн тогтоолтой бол уг хугацаа дууссан байх;
- Иргэний хувьд төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй байх /Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтад оролцох иргэдэд хамааралгүй./;
- Албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг бүрэн хангасан байх;
- Энэ зард тавигдсан “Албан тушаалын тодорхойлолт”, “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам” болон шаардлага, зөвлөмжтэй танилцсан байх.

**Хоёр. Сул орон тоог нөхөхдөө журамд заасан болзол, шаардлагыг хангасан төрийн албан хаагч, нөөцөд байгаа иргэдээс дараах дарааллын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулна. Үүнд:**

- Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоонд шатлан дэвших зарчмын дагуу төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчид болон нөөцөд байгаа иргэд хамт өрсөлдөнө. /Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1/
- Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоонд тухайн байгууллагад болон холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчид хамт өрсөлдөнө. /Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2/
- Тухайн байгууллагад болон бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагч бүртгүүлээгүй эсхүл албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангаагүй бол төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөд байгаа иргэд өрсөлдөнө. /Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3/
- Туслах түшмэлд хамаарах гүйцэтгэх албан тушаал болон Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сул орон тоог нөхөхдөө дараалал харгалзахгүй сонгон шалгаруулж нөхнө.

**Гурав. Цахимаар ирүүлэх баримт бичиг**

- Төрийн албан хаагчийн анкет;
- Цээж зураг;
- Иргэний үнэмлэхийн хуулбар;

- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/ Хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг гэрчлэх баримт бичиг—Төрийн албан хаагч, иргэний Удирдлагын академийн тодорхойлолт (сонгон шалгаруулалтын комисст хандсан, сургалтад хамрагдаж, төгссөн байх хугацаа гэх мэтийг тусгасан)-ыг үндэслэн сонгон шалгаруулалтын бүртгэлд хамруулах эсэхийг шийдвэрлэнэ;
- Нийгмийн даатгалын дэвтэр /Хөдөлмөрийн дэвтэр/-ийн хуулбар, цахим лавлагаа; /e-mongolia–аас татан авах/
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд холбогдох баримт;
- Төрийн албаны ерөнхий шалгалтын дүнгийн хуудас /зөвхөн нөөцөд бүртгэлтэй иргэний хувьд, Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтад оролцох иргэдэд хамааралгүй./;
- Төрийн албанд ажилласан жил тооцох, төрийн жинхэнэ албаны нөөцөд байгааг тогтоох зорилгоор албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар /Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтад оролцох иргэдэд хамааралгүй./;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–аас татан авах/.

*Төрийн албаны тухай хуулийн 26.3-т заасан ажилласан жилийг тогтоосон тусгай шаардлагын 50 хувийг хангасан төрийн жинхэнэ албан хаагчийн хувьд нэмэлтээр дараах баримт бичгийг бүрдүүлнэ:*

– *Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан тухайн албан хаагчийг шатлан дэвшүүлэх тухай бичгээр гаргасан санал;*

– *Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан тухайн албан хаагчийг сүүлийн 12 сарын хугацаанд сахилгын шийтгэл, ёс зүйн хариуцлага хүлээгээгүй тухай бичгээр гаргасан лавлагаа;*

– *Сүүлийн гурван удаагийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ нь хамгийн “хангалтгүй” үнэлгээ аваагүй байх.*

### **Дөрөв. Албан тушаалд тавигдах шаардлага**

Зарлагдаж буй сул орон тоонд тухайн албан тушаалд тавигдсан боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагыг хангасан, энэ албан тушаалд ажиллахыг хүссэн иргэн бүртгүүлнэ. /энд дарж зөвлөмжтэй танилцана уу/

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлд 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдөр нэмэлт өөрчлөлт орж төрийн албан тушаалд тавих тусгай шаардлага өөрчлөгдсөн тул тухайн албан тушаалын тодорхойлолтын “Туршлага” хэсэгт тавигдсан шаардлагыг Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1, 23.2.2, 23.2.3 дахь заалтыг үндэслэн төрийн албаны тусгай шалгалтын бүртгэлд хамруулна. /энд дарж хуультай танилцана уу/

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлагад орсон өөрчлөлтийг баримтлан төрийн албаны тусгай шалгалтын бүртгэлд хамруулна. /энд дарж тогтоолтой танилцана уу/

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 487 дугаар тогтоолоор “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-ыг шинэчлэн баталсан. /энд дарж тогтоолтой танилцана уу/

## Тав. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг хүлээн авах ба бүртгэх

Сонгон шалгаруулалтын комисс болон ажлын хэсэг тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад оролцох иргэний хүсэлт, холбогдох баримт бичгийг зард заасан хуваарийн дагуу цахимаар хүлээн авна.

Бүртгүүлэхээр ирүүлсэн иргэний хүсэлт, холбогдох баримт бичгийн бүрдэл болон тухайн албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг хангаж байгаа эсэхийг комисс нягтлан шалгаад бүртгэх эсэх тухай шийдвэрийг комисс хуралдаанаараа хэлэлцэн гаргах ба бүртгээгүй бол энэ тухай шалтгааныг “Цахим систем”-ээр хүсэлт гаргагчид мэдэгдэнэ. /Өөрийн эрхээр нэвтрэн орж “Шалгалтын мэдээлэл” цэсээс харна./

Комисс тухайн албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг хангаж байгаа албан хаагч, иргэдэд шалгалт өгөх өдөр, цаг, байршлыг “Цахим систем”-ээр нийтэд мэдээлнэ. /”Бүртгэлд хамрагдсан иргэд” цэсээс харна./

Шалгалтын бүртгэлтэй холбоотой гомдлыг шийдвэрлэх, шалгалтын зохион байгуулалттай холбоотойгоор шалгалт өгөх хуваарьт өөрчлөлт орсон тохиолдолд “Цахим систем”-ээр нийтэд мэдээлнэ.

## Зургаа. Сонгон шалгаруулалтын хуваарь

Сонгон шалгаруулалтыг дараах агуулгын хүрээнд зохион байгуулна. (уншиж судлах эрх зүйн баримт бичгийн жагсаалт, жишиг сорилыг энд дарж үзнэ үү)

Дэлгэрэнгүй: <https://hh.csc.gov.mn/view/c65fd187-dcd9-460e-aea1-0f528c75100a>

### ЗАРЛАГДСАН АЖЛЫН БАЙР

№	БАЙГУУЛЛАГА	ДОТООД НЭГЖ	АЛБАН ТУШААЛЫН НЭРШИЛ	АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ ЗЭРЭГЛЭЛ	ХАРИУЦСАН АСУУДАЛ
1	Орхон Нийгмийн даатгалын газар	Захиргаа, хяналтын хэлтэс	Гүйцэтгэх	ТЗ - 9	Цахим үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
2	Орхон Нийгмийн даатгалын газар	Захиргаа, хяналтын хэлтэс	Гүйцэтгэх	ТЗ - 9	Сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн